

# ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН<sup>1</sup>

*Кино урлагийг дэмжих тухай хуулийн  
төсөл боловсруулах тухай*

## Ерөнхий мэдээлэл

“Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолын хавсралтын 57-д “Кино урлагийн салбарын хөгжлийг төрөөс дэмжих, кино үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, уран бүтээлчдийн эрхийг хамгаалах чиглэлээр эрх зүйн орчинг бүрдүүлэх, хууль хоорондын уялдааг хангах” чиглэлээр Киноны тухай хууль боловсруулахаар, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.42-т “Соёлын тухай хуулийг шинэчлэн баталж, киноны тухай, музейн тухай хуулийг боловсронгуй болгон хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ” гэж, Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 3.2.42 дахь зорилтын 3-т “Киноны тухай хуулийн төслийн боловсруулж батлуулах” гэж тус тус заасан.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу кино урлагийг дэмжих тухай хуулийн төслийн тандан судалгааг хийв.

Соёлын тухай хуулиар зохицуулах харилцаа нь Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал<sup>2</sup> /цаашид “Аргачлал” гэх/-ын 1.3-т заасан хүрээнд хамаарахгүй тул урьдчилан тандан судлах ажиллагааг Аргачлалын 2.1-д заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

## НЭГ.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Монгол Улсад анх кино гаргаж байсан баримт 1912 оноос эхлэх боловч, МАХН-ын 1923 онд хуралдсан 2-р бага хурлаас “кино урлагийн ач холбогдол”-ыг үнэлэн 1925-1926 оны хурлын тогтоолд “кино урлагийг хөгжүүлэх” талаар шийдвэрлэж, ЗХУ-тай “кино худалдан авах, ... кино хийлгэх” хэлцэл байгуулан, 1933 онд Улсын кино зураг эрхлэх хороо байгуулагдаж, Монгол кино үйлдвэр анх Майн нэгний 47 жилийн ойг Улаанбаатар хотод анх удаа тэмдэглэсэн тухай “Майн баярын 47 жил” нэг бүлэгт баримтат кино бүтээснээр кино урлагийн салбарын түүх эхэлдэг. 1936-2000 онд бүрэн хэмжээний 292 уран сайхны кино, 900 гаруй баримтат кино бүтээсэн байна.

<sup>1</sup> Судалгааг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу боловсруулав.

<sup>2</sup> Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

1990 оноос өмнө кино урлаг нь нэг намын бодлогоор үзэл сурталжсан, хатуу хяналтын дор бүтээгддэг байсан ч соёл, ахуй амьдрал, тухайн үеийн нийгмийн бодит тусгал болсноороо соёлын үнэт өв болсон байна. Мөн төрийн бодлогоор бэлтгэгдсэн уран бүтээлчид, тухайн цаг үеийнхээ дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж, төрөөс санхүүжилтийг бүрэн шийдвэрлэж, киног бүтээх, түгээх үйл ажиллагааг бүрэн дэмжиж байсны хувьд далайцтай, гүнзгий утга агуулгатай, сэтгэлгээ, уран сайхны болон дүр, дүрслэл хэллэгийн хувьд өндөр түвшний уран бүтээлүүд төрөн гарч байсан.

1990 оноос хойш уран бүтээлчид чөлөөтэй сэтгэж, бүтээх нөхцөл бүрдсэн ч кино бүтээх, түгээх тогтолцоо алдагдаж, кино үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчлээгүй, кино үйлдвэр нь барилга, эд хөрөнгөө түрээслэх төдий байдлаар ажиллах болсон. Кино урлаг нь зөвхөн кино продакшн, уран бүтээлчдийн үйл ажиллагааны үр дүнд өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар бие даан хөгжиж байгаа нь сайшаалтай боловч Улаанбаатар хот дахь кино театруудас хамааралтайгаар хэт удаан хөгжиж байна. Гадны соёл нэвтэрч, иргэдийн мэдээлэл авах, дэлхийн шилдэг уран бүтээлийн шууд үзэх боломж бий болсон өнөө үед гадаадын киноны хэв маяг, загварыг хэт дуурайсан, үзэгчдийн хэрэгцээ, шаардлагыг хангахгүй кинонууд олноор бүтээгдэж, иргэдийн сонирхолыг татсан, олон улсын кино наадмаас шагнал хүртсэн бүтээлүүд харьцангуй цөөн байна.

2000-2016 онд 400 гаруй уран сайхны кино бүтээгдсэн. Засгийн газрын 1997 оны 74 дүгээр тогтоолоор "Монгол улсын нийгэм, улс төр, эдийн засгийн амьдралд гарч байгаа түүхэн тэмдэглэлт үйл явдлыг архивлан хадгалах зорилгоор бүтээж байгаа "Түүхийн хүрд" баримтат ... киноны зардлыг улсын төсөвт жил бүр тусган санхүүжүүлж байх" үүргийн дагуу улс төр, нийгэм, эдийн засаг, соёл, боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, биеийн тамир спортын салбарт гарч байгаа түүхэн үйл явдлыг кино архивт авч хадгалах зорилгоор бүтээж байгаа "Түүхийн хүрд" 12 бүлэг кино хийхэд жил бүр санхүүжилт үзүүлж байна.

Кино урлагийн чиглээр мэргэжилтэн бэлтгэдэг их дээд сургуулиуд 1990 оноос хойш зөвхөн найруулагч, зураглаач, жүжигчин, засал чимэглэлч, зураг дизайн, кино механикч гэсэн чиглэлээр 2000 гаруй мэргэжилтэн төгсгөсөн бөгөөд кино үйлдвэрлэлийн бүхий л чиглэлд ажиллах мэргэшсэн боловсон хүчин бүрэн бэлтгэгдээгүй, олон улсын түвшинд ажиллах ур чадвар хангалтгүй, кино урлагийн мэргэжлийн үнэлэлт, дүгнэлт өгөх судлаачид дутмаг байна.

Цаашдаа кино урлаг нь олон улсын жишиг, шаардлагын дагуу студийн зарчмаар ажиллаж, өөрийгөө санхүүжүүлэх замаар хөгжих нь тодорхой боловч кино урлагаар дамжуулан үндэсний соёл, агуулгыг таниулах, соёлын аюулгүй байдал, хүүхэд, залуучуудын ёс суртахууны төлөвшлийн нөлөөллийг ашиглах, Монгол Улсыг сурталчлах хөшүүрэг болгох үүднээс төрөөс болон аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулалтыг татахад дэмжлэг үзүүлэх, тодорхой хяналт, хязгаарлалт тогтоох зэрэг шаардлагын үүднээс асуудлыг хөндөн судлав.

Иймд Аргачлалын 3-т заасны дагуу асуудалд дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоож, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлж, асуудлыг үүсгэж байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон болно.

## 1.1. Асуудлын хамрах хүрээг тодорхойлсон байдал:

1. Кино урлагийн салбарын статистик мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэн баяжуулах, статистик мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгож нэгтгэх, мэдээлэл, лавлагаагаар хангах, салбарын холбогдох бусад мэдээллийг нэгтгэн, судалгаа шинжилгээний хэрэглэгдэхүүн бүрдүүлэхэд төрийн зохион байгуулалт шаардлагатай байна.

2. Кино урлаг нь олон улсын жишиг, шаардлагын дагуу студийн зарчмаар ажиллаж, өөрийгөө санхүүжүүлэх замаар хөгжих нь тодорхой боловч аливаа улс өөрийн соёлын аюулгүй байдал, салбарын хэмжээнд баримтлах бодлого, улс орноо сурталчлах үүднээс кино урлагийн хүчтэй нөлөөлөл, ач холбогдлыг ашиглах нь чухал үндэсний соёл, өвөрмөц онцлог, өв уламжлалыг эерэгээр харуулсан, монгол агуулга бүхий киног төрөөс дэмжих шаардлагатай байна. "Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, Соёлын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг уядруулах "Гадаад сурталчилгааны бүтэц бий болгоход" холбогдох яамд хамтран ажиллах шаардлагатай байна. Гадаад сурталчилгааны бүтэц, нэгдсэн бодлого, хамтын ажиллагааны дүнд кино урлагаар дамжуулан Монгол Улсыг сурталчлах, олон улсын кино наадамд оролцох, монголд олон улсын кино наадам зохион байгуулахад төрийн бус байгууллага, уран бүтээлчидтэй хамтран ажиллах шаардлагатай байна.

3. 2015 онд Соёлын тухай хуульд нэмэлт оруулж, үндэсний киноны эзлэх хувийг зааж өгсөн бөгөөд зөвхөн хувь тогтоож, шаардлага тавих нь бус үндэсний киноны чанарыг сайжруулах, орчин үеийн техник технологийн ололт амжилтыг нэвтрүүлэх, уран бүтээлчдийг олон улсын хандлага, арга барилд суралцах, кино зохиол, найруулагч, инженер, техникийн ажилтнуудыг бэлтгэх, Улаанбаатар хот болон аймгийн төвүүдэд шаардлага хангасан кино театр байгуулах, кино театрын зориулалтаар тоноглох, сумдад кино үзвэрийн цэг бий болгоход аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулалтыг татахад дэмжлэг үзүүлэх замаар энэ нөхцөлийг хангах шаардлагатай байна.

4. Аймгийн төвүүдийг кино театртэй болгох, сумдад кино үзвэрийн цэг байгуулах, тэдгээрийг нэгдсэн сүлжээнд холбоход татварын дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын тусгай сан, Сум хөгжүүлэх сан зэргээс санхүүжүүлэхэд анхаарах шаардлагатай юм.

5. Кино урлагийн чиглээр мэргэжилтэн бэлтгэдэг их дээд сургуулиуд 1990 оноос хангалттай тооны мэргэжилтэн бэлтгэсэн боловч олон улсын түвшин ажиллах ур чадвар, боломж хангалтгүй, зохиол бичих, \зураг авах\ эвлүүлэг, өнгө засал, дууны найруулга, бусад техникийн ажилтан гэсэн үйлдвэрлэлийн бүхий л чиглэлд ажиллах мэргэшсэн уран бүтээлчид бүрэн бэлтгэгдээгүй байна. Мөн кино урлагийн мэргэжлийн үнэлэлт, дүгнэлт өгөх, шүүмж судлалыг хөгжүүлэх, уран бүтээлчид алдаагаа олж, харах, бусдын алдаанаас суралцах, хурдан хөгжихөд нь дэмжлэг болохуйц, үндэслэл бүхий, зөв бодитой шүүмж судлаачдийг бэлтгэж, мэргэшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

6. Өөрөөр хэлбэл манай улсын мэргэжилтэн бэлтгэх сургалт, арга барил, бэлтгэгдсэн уран бүтээлчдийн мэргэжлийн ур чадварын хувьд барууны орнуудаас

нэлээд хоцорсон нь үзэгчидийн үзэж буй кино, хандлагаас хоцорсон дүгнэх үнэслэлтэй байна. Үзэгчдийн үзэж буй киноны түвшинд хүрэхийн тулд кино урлаг өндөр хөгжсөн орны сургалт, арга барил, сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлэх, нутагшуулах, уран бүтээлчдийн хөгжлийг дэмжих нь чухал байна.

Энэ хүрээнд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/265 дугаар тушаалаар байгуулсан хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүдээс гарсан санал, улсын хэмжээнд зохион байгуулсан “Соёл урлагийн ажилтны улсын II чуулган”-аас гарсан зөвлөмж, соёл, урлагийн салбарын байгууллага, уран бүтээлчдээс ирсэн санал, холбогдох тооцоо, судалгаа, дүгнэлт зөвлөмж зэргийг үндэслэсэн болно.

## **1.2. Асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа бүлгийг тогтоох:**

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 8-д “иргэн нь соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй” гэж заасан байдаг.

Кино үйлдвэрлэл эрхлэхэд оролцож байгаа иргэний хуулийн этгээд, кино уран бүтээл сонирхогч иргэд, хуулийн этгээд, төрийн байгууллага, албан хаагчийн буюу Монгол Улсын нийгэм, соёлын харилцаанд оролцогч бүх талуудын эрх ашиг сонирхол уг хуулиар шууд болон шууд бусаар хөндөгдөнө.

## **1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан, нөхцөлийг тогтоох:**

Холбогдох мэдээлэл, судалгаа, дээр дурдсан хууль, эрх зүйн орчны нөхцөл байдал, олон улсын гэрээ конвенц зэргээс үзэхэд шийдвэрлэвэл зохих дараахь асуудлууд байсаар байна.

- Үзэгчдийн хандлага, мэдээлэл хүртэж буй хэлбэр, хурдаас монголын кино уран бүтээлчдийн хөгжил нилээд хоцорсон, кино урлаг өндөр хөгжсөн орны сургалт, арга барил, сургалтын хөтөлбөрийг эх орондоо нэвтрүүлэх, нутагшуулах, уран бүтээлчдийн хөгжлийг дэмжих шаардлага үүссэн.

- Кино уран бүтээл нь өндөр зардлаас бүтээгддэг боловч хууль бусаар цахим сүлжээнд тавигдах зөрчил байнга гарч, уран бүтээлчид зардлаа нөхөж чадахгүйд хүрсээр байна

- Төрийн болон орон нутгийн байгууллагууд нь салбарын, аймаг, сумдын, байгууллагуудын ойд зориулан төсвийн хөрөнгөөр стандарт шаардлага хангахгүй баримтат кино бүтээх, Засгийн газрын тогтоолын дагуу түүхэн үйл явдал, төр, нийгмийн зүтгэлтний ой тэмдэглэх ажлын хүрээнд \2010 онд-5, 2011-6, 2012 онд -5, 2013 онд -1, 2014 онд -2, 2015 онд 3, 2016 онд -4, 2017онд -1\ тухайн үйл явдал, алдартны талаар баримтат кино бүтээлгэж байна. Батлан хамгаалах яамны захиалгаар 2010 онд “Тусгай салаа” телевизийн олон ангит кино, “Тусгай салаа-2” бүрэн хэмжээний уран сайхны кино, “Догшин хар сүлдний нууц” түүхэн баримтат кино, Эрүүл мэндийн яамны захиалгаар 2011 онд “Өдөр өдрийн нар”, Цагдаагийн Ерөнхий газраас санаачлан 2012 онд “Амьдрал чиний төлөө”, 2013 онд Хил хамгаалах Ерөнхий

газраас МҮОНРТ-тэй хамтран “Босго тотго”, 2014 онд Монгол Улсын Шадар сайдын санаачлагаар Онцгой байдлын ерөнхий газар, Монголын үндэсний олон нийтийн телевизтэй хамтран “Нарны жим” олон ангит уран сайхны кино бүтээсэн байна. Сум, аймаг, байгууллагын ой, дээрх уран сайхны кинонуудад зарцуулсан төсөв, хөрөнгийн талаарх мэдээлэл тодорхойгүй байна.

- Кино үнэ өртөг өндөртэй бүтдэг урлаг тул зохиогчийн эрхийг хамгаалах, цахим хууль бус үйлдлийн нэн даруй таслан зогсоох талаар төрийн холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг хангах.

- Компаниуд дангаараа болон хамтарч санхүүжүүлсэн хүүхдийн болон түүхэн уран сайхны кинонд зарцуулан зардлыг татвар ногдох орлогоос хасч тооцох замаар түүхэн уран сайхны кино бүтээх сонирхолыг нэмэгдүүлэх, түүх, соёлоо хойч үедээ таниулах,

- Монгол кино нэгтгэлийн статусыг тодорхой болгох, студи, тоног төхөөрөмж, материал хэрэгслийг хувийн студи продакшинд хөнгөлөлттэй үнээр ашиглуулах, “Түүхийн хүрд” баримтат киноны чанарыг дээшлүүлэх, тодорхой шаардлагыг гэрээнд тусгаж байх.

## **ХОЁР.АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ**

Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна.

Хуулийн төслийг боловсруулах зорилго нь киноны салбарын хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, орчин үеийн дэвшилтэт техник, технологи бүхий кино үйлдвэрлэлийн дэд бүтцийг бий болгож монгол киног дэлхийн зах зээлд гарган өрсөлдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, хүүхэд, залуучуудад эх оронч үндэсний үзэл, ёс суртахууныг төлөвшүүлэхэд чиглэсэн кино бүтээлийг улсын захиалга, санхүүжилтээр бүтээх, киног эдийн засгийн хөшүүрэг болгон хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

## **ГУРАВ.АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛУУДЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргалчлал –д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу “кино урлагийг дэмжих тухай” хуулийн зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуулийн агуулга, үзэл баримтлалд нийцүүлж, киноны салбарын хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, орчин үеийн дэвшилтэт техник, технологи бүхий кино үйлдвэрлэлийн дэд бүтцийг бий болгож монгол киног дэлхийн зах зээлд гарган өрсөлдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, хүүхэд, залуучуудад эх оронч үндэсний үзэл, ёс суртахууныг төлөвшүүлэхэд чиглэсэн кино бүтээлийг улсын захиалга, санхүүжилтээр бүтээх, киног эдийн засгийн хөшүүрэг болгон хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгыг хангаж чадах эсэх, хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

*Хүснэгт 1*

Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн	
1	Тэг хувилбар	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй ч, сөрөг үр дагавар улам бүр нэмэгдэнэ.	Үр дүн сөрөг
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Зорилгыг бүрэн хангахгүй ч байгууллага, иргэдийн идэвхи, хяналт тодорхой хэмжээнд нэмэгдэх магадлалтай.	Зардал тодорхой хэмжээнд гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг бүрэн бууруулж чадахгүй.	Дангаараа үр дүнд хүрэхгүй
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Тодорхой тохиолдолд татвар, хураамжаас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх нь зарим талаар соёлын байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих ач холбогдолтой ч зорилгыг бүрэн хангаж чадахгүй.	Тодорхой хэмжээний зардал гарна. Гэвч асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг бууруулж чадахгүй.	Дангаараа үр дүнд хүрэхгүй
4	Төрөөс санхүүгийн интервенци хийх	Кино урлагийг чиглэлд тодорхой мөнгөн дэмжлэг үзүүлэх нь зарим талаар эдгээр байгууллагын үйл ажиллагааг дэмжих хэдий ч зорилгыг хангаж чадахгүй.	Тодорхой хэмжээний зардал гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг бууруулж чадахгүй.	Үр дүнд хүрэхгүй
5	Захиргааны шийдвэр гаргах	төдийлөн ахиц гаргаж чадахгүй. Энэ салбарын хүний нөөцийн талаар авч хэрэгжүүлэх зорилгод сөрөг нөлөө үзүүлнэ.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад нөлөөлж чадахгүйгээс гадна соёлын салбар дахь хүний нөөцийн бодлогыг дэмжих зорилгод сөрөг үр дагаварыг үүсгэхээр байна.	Үр дүн сөрөг
6	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	орчин үеийн дэвшилтэт техник, технологи бүхий кино үйлдвэрлэлийн дэд бүтцийг бий болгож монгол киног дэлхийн зах зээлд гарган өрсөлдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, хүүхэд, залуучуудад эх оронч үндэсний үзэл, ёс суртахууныг төлөвшүүлэхэд чиглэсэн кино бүтээлийг улсын захиалга, санхүүжилтээр бүтээх, эрх зүйн орчин бүрдэж, хариуцлага өндөржинө.	Тодорхой хэмжээний зардал гарах боломжтой боловч энэ хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлнэ.	Үр дүнтэй

Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх замаар олон нийтийг мэдээллээр хангах хувилбарыг бусад хувилбартай харьцуулахад иргэд, соёлын байгууллагуудыг идвэхжүүлэх, хяналтыг сайжруулах, зардал бага гарах зэрэг эерэг нөлөөтэй боловч дэвшүүлсэн зорилгыг дангаараа хангах боломжгүй юм.

Харин хуульд тусгайлан заасан тохиолдолд зарим соёлын салбар дахь байгууллагуудад дэмжлэг үзүүлэх чиглэлээр (татвараас чөлөөлөх, үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлэх чиглэлээр дэмжлэг үзүүлэх гэх мэт) нэмэлт зардал гарч болно.

## **ДӨРӨВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАНУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ**

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон 2 хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

*Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг үнэлгээний тайланд хавсаргасан хавсралт-хүснэгт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.*

### **4.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө**

Хувилбар 1, 2-ын хүрээнд хүний эрхэд үзүүлэх үр нөлөөг үнэлэхэд хуулийн төсөл боловсруулах хувилбар илүү үр дүнтэй,

### **4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө**

Сонгосон хоёр хувилбарын аль аль нь дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөлөл зэргийг бий болгох сөрөг үр даавар үүсгэхгүй. Харин хуулийн төсөл боловсруулах хувилбар нь соёлын салбар дахь оюуны өмчийн аливаа эрхийг хөндөхгүй байх, энэ салбар дахь судалгаа шинжилгээ, нээлт, шинэ бүтээлийг дэмжихэд эерэг нөлөө үзүүлэх бөгөөд тодорхой бүс нутагт ажлын байр бий болгох, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд хуулийг нийцүүлэх зэрэг эерэг үр дагавартай байна. Харин хувилбарын аль аль нь улсын болон орон нутгийн төсөвт тодорхой ачаалал үүсэх боломжтой боловч Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, эрх ашгийг хангах хүрээнд ач холбогдолтой тул ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй гэж үзэж байна.

Иймд дээрх хоёр зохицуулалтын аль ч хувилбарыг хэрэгжүүлсэн тодорхой зардал гарах боловч хариуцсан төрийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэх, үйл явц илүү тодорхой, ил тод, хэрэгжихүйц болохоор байна.

### **4.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө**

Сонгосон хоёр хувилбарын хувьд аль аль нь нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид эерэгээр нөлөөлнө.

Хуулийн төсөл боловсруулах хувилбарыг хэрэгжүүлэх нь өнөөдөр тулгамдаад байгаа олон асуудлыг шийдвэрлэх, илүү үр дүнг бий болгох магадлалтай байгаагаас гадна соёл, соёлын өвийг хамгаалахад чухал ач холбогдолтой байна. Харин аль аль хувилбар нь олон нийтийг үндэсний соёлыг хамгаалах, анхаарлаа хандуулах, олон нийтэд зөв төлөвшил бий болгоход эерэг нөлөө үзүүлнэ.

### **4.4.Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө**

Хувилбарууд бүгд байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

#### **4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх**

Сонгосон хоёр хувилбарын хувьд аль аль нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа боловч хуулийн төсөл боловсруулах хувилбар нь Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх буюу Соёлын тухай хуулиар зохицуулах харилцааг конвенцид заасны дагуу илүү өргөн хүрээнд авч үзэх нөхцөлийг бүрдүүлэхээр байна.

#### **ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ**

Аргачлалын 7-д зааснаар хувилбаруудын эерэг болон сөрөг талуудыг:

- Зорилгод хүрэх байдал;
- Зардал, үр өгөөжийн харьцаа;
- Хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх;
- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараах дүгнэлтийг хийлээ.

Эрх зүйн орчныг сайжруулахын тулд хувилбар 1-ийг буюу Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх замаар соёлын салбарыг дэмжих олон нийтийн чиг хандлагыг сайжруулах нь олон нийтийн хэмжээнд энэ салбарыг дэмжих, үндэсний эрх ашиг, соёлоо хамгаалах сайн дурын үйл ажиллагааг өрнүүлж болох боловч энэ нь асуудлыг цогцоор шийдвэрлэж чадахгүйд хүрч болно. Тухайлбал: хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг хуульд тусгахгүйгээр хэрэгжилтийг хангахад бэрхшээл учрахаас гадна асуудлыг цогц хэлбэрээр зохицуулах, соёлын салбар бүрийн оролцоог бүрдүүлэх, мөн иргэд, хуулийн этгээдэд тавих шаардлага, хязгаарлалт, татвар, хураамжийн хөнгөлөлт, чөлөөлөлт, соёлын салбар дахь хөрөнгө оруулалт, нэр томьёо, бүртгэл статистик зэрэг асуудлыг зөвхөн хуулиар зохицуулах тул бэрхшээл үүснэ.

Хувилбар 2 буюу хууль батлан хэрэгжүүлэх нь өнөөгийн тулгамдаад байгаа сөрөг үр дагаврыг бууруулах, хяналт, үр дүнг сайжруулах зэрэг асуудлыг цогцоор шийдвэрлэх боломж өндөр байна. Гэвч энэ зохицуулалт нь дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, манай улсын эдийн засаг, нийгэм зэрэг нөхцөл байдалд нийцүүлэн оновчтой хэлбэрээр хуульчлах шаардлагатай байна.

#### **ЗУРГАА.ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

Хуулийн төсөл боловсруулах хувилбар сонгогдсон тохиолдолд Аргачлалын 8-д заасны дагуу олон улсын эрх зүйн зохицуулалт, бусад орны адил төстэй эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийх зорилгоор энэ чиглэлээр өмнө хийгдсэн судалгааны мэдээлэлд үндэслэн дараах олон улсын эрх зүйн зохицуулалт болон улсыг сонгон авсан:



Оросын Холбооны Улсын кино урлагийг төрөөс дэмжих тухай холбооны хууль: Оросын Холбооны Улсын кино урлаг нь соёлын салшгүй хэсгийн хувьд төрийн дэмжлэгтэйгээр хадгалагдаж, хөгжих ёстой гэж үзэж кино урлагийг хадгалж, хөгжүүлэхэд төрийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлж, кино урлагийг хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх журмыг тогтоож өгсөн.

Кино урлагийг төрөөс дэмжих арга хэмжээ нь кино урлагийг хадгалж, хөгжүүлэхтэй холбогдсон холбооны төсөл боловсруулж, хэрэгжүүлэх; холбооны төсөвт кино урлагт зарцуулах хөрөнгө төлөвлөхөд оролцох; кино урлагийн дотоод бүтэц хөгжүүлэх явцыг зохицуулах; киноны Улсын регистр хөтлөх, Оросын Холбооны Улсын нутаг дэвсгэр дээр кино гаргалт, кино үзүүлэлтийг зохицуулах зорилгоор кино гаргалтын эрх /гэрчилгээ/ олгох, Оросын Холбооны Улсын Засгийн газраас тогтоосон журмын дагуу киноны эрх эзэмшигчдийн эрхийг хамгаалах, үзэгчдийн насны байдлыг тогтоох; үндэсний киноны гэрчилгээ олгох; кино урлагийн салбарын боловсрол, кино урлагийн шинжлэх ухаан хөгжүүлэх, уран бүтээлч болон инженер-техникийн боловсон хүчин бэлтгэхэд туслах; кино урлагийн салбарын төрийн статистикийн бүртгэлийн систем боловсруулах; кино урлагийн салбарын олон улсын харилцаа хөгжүүлэх, олон улсын кино урлагийн байгууллага болон хороонд төлөөлөх, зөвөлгөөн, бага хурал, бусад арга хэмжээнд оролцох байдлаар тусгагдсан.

Кино урлагт үзүүлэх төрийн дэмжлэгийн үндсэн арга хэмжээ нь:

- үндэсний, тэр дундаа хүүхэд залуучуудад зориулсан кино, үндэсний анхны гарааны кино туурвихад;
- кино урлагийн материал-техникийн суурь хадгалж, хөгжүүлэхэд;
- үндэсний кино гаргах, үзүүлэх нөхцөл бүрдүүлэх;
- боловсролын болон шинжлэх ухаан-техникийн хөтөлбөр хэрэгжүүлэхэд;
- киноны наадам болон бусад соёлын арга хэмжээ зохион байгуулахад;
- олон улсын киноны наадам болон бусад олон улсын соёлын арга хэмжээнд оролцоход чиглэгдэнэ.

Холбооны нэгдсэн мэдээллийн сан ажиллуулж дуу, дүрс бүхий бүтээлийн онцгой эрх хамгаалах, хэрэглэгчдийн эрх хамгаалах, кино урлагийн салбарын асуудал эрхэлсэн холбооны гүйцэтгэх засаглалын төрийн захиргааны байгууллагыг кино гаргалтын дотоодын зах зээлийн байдлын тухай үнэн зөв, шуурхай мэдээллээр хангадаг. Киноны танхимд төлбөртөйгээр кино үзүүлэгч этгээд киноны танхимд кино үзүүлэхдээ зарагдсан тасалбар бүрийн тухай кинотеатрын нэр, огноо, цаг, үзүүлэх киноны ээлж, киноны нэр, кино гаргалтын гэрчилгээний дугаар, киноны танхимын дугаар буюу нэр, эгнээний дугаар, суудлын дугаар, тасалбарын үнэ, тасалбарын хөнгөлөлт заасан мэдээллийг холбооны мэдээллийн санд хүргүүлэх үүрэгтэй.

Сангийн операторын чиг үүрэг хэрэгжүүлэхтэй холбогдсон зардлыг тогтоосон журмын дагуу холбооны төсвөөс кино урлагийн салбарын асуудал эрхэлсэн холбооны гүйцэтгэх засаглалын төрийн захиргааны байгууллагад хуваарилсан кино урлагт үзүүлэх төрийн дэмжлэгийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

Мэдээллийн нэгдсэн сан ажиллах журам, санд хадгалагдах мэдээлэл гаргаж өгөх нөхцлийг Оросын Холбооны Улсын Засгийн газар тогтооно.

Мэдээллийн нэгдсэн санг ашиглаж, энэхүү зүйлийн дагуу кино үзүүлэгчдэд мэдээлэл гаргаж өгөх журам, шаардлагатай техникийн хэрэгсэл, программын хангамж, мэдээлэл хамгаалах хэрэгсэлд /тэр дундаа зөвшөөрөлгүй нэвтрэхээс/ тавигдах шаардлага, кино үзүүлэгч, сангийн оператор хооронд мэдээлэл солилцох журмыг кино урлагийн салбарын асуудал эрхэлсэн холбооны гүйцэтгэх засаглалын төрийн захиргааны байгууллага батална.

Энэхүү зүйлд зааснаар кино үзүүлэгч мэдээллийг гаргаж өгөөгүй, эсвэл ийм мэдээллийг бүрэн бус хэмжээгээр буюу гажуудуулсан байдалтай гаргаж өгсөн бол Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

## **Гуравдугаар бүлэг. КИНО УРЛАГИЙГ ТӨРӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХ**

### **7-р зүйл. Кино урлагийг төрөөс санхүүжүүлэх нөхцөл болон журам**

Кино урлагт үзүүлэх төрийн дэмжлэгийн нэг хэлбэр нь хэсэгчилсэн төрийн санхүүжилт.

Төрийн санхүүжилтийг кино урлагийн салбарын асуудал эрхэлсэн холбооны гүйцэтгэх засаглалын төрийн захиргааны байгууллага “Төрийн болон орон нутгийн хэрэгцээнд бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх захиалга байршуулах тухай” Холбооны хуульд заасан журмын дагуу сонгогдсон үндэсний киноны продюсер, гаргагч, үзүүлэгчдэд зохих санхүүгийн жилд кино урлагт холбооны төсвөөс хуваарилсан хөрөнгийн хэмжээгээр хөрөнгө хуваарилах, эсвэл зохих санхүүгийн жилийн холбооны төсвийн тухай хууль, төлөвлөгөөт үед заасан тохиолдол болон нөхцөл, тэдгээрийн дагуу Оросын Холбооны Улсын Засгийн газраас батлагдсан эрхзүйн хэм хэмжээ тогтоосон актын дагуу холбооны төсвөөс тусламж үзүүлэх замаар шийдвэрлэнэ.

Төрийн санхүүжилтийг кино урлагийн салбарын асуудал эрхэлсэн холбооны гүйцэтгэх засаглалын төрийн захиргааны байгууллага болон үндэсний киноны продюсер, гаргагч, үзүүлэгч хооронд байгуулсан улсын гэрээнд болон /буюу/ зохих санхүүгийн жилийн холбооны төсвийн тухай хуулийн болон төлөвлөгөөт үеийн дагуу Оросын Холбооны Улсын Засгийн газраас батлагдсан эрхзүйн хэм хэмжээ тогтоосон актанд заасан зорилгоос бусад зорилгоор ашиглахыг хориглоно.

### **8-р зүйл. Үндэсний кино туурвилыг төрөөс санхүүжүүлэх**

Кино урлагийн салбарын асуудал эрхэлсэн холбооны гүйцэтгэх засаглалын төрийн захиргааны байгууллага зохих санхүүгийн жилд холбооны төсвийн тухай холбооны

хуулийн дагуу кино урлагт хуваарилсан хөрөнгийн хэмжээнд үндэсний кино туурвихад хөрөнгө гаргах тухай шийдвэр гаргана.

Үндэсний кино туурвихад төрийн санхүүжилт кино туурвихад шаардлагатай төсөвт өртгийн 70 хувиас хэтэрч болохгүй.

Онцгой тохиодолд киноны төслийн уран сайхны болон соёлын ач холбогдолыг авч үзсэнээр кино урлагийн салбарын асуудал эрхэлсэн холбооны гүйцэтгэх засаглалын төрийн захиргааны байгууллага үндэсний киног түүнийг туурвихад шаардлагатай төсөвт өртгийг 100 хувь төрөөс санхүүжүүлэх тухай шийдвэр гаргана.

Төрийн санхүүжилтийг "Төрийн болон орон нутгийн хэрэгцээнд бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх захиалга байршуулах тухай" Холбооны хуульд заасан журмын дагуу үндэсний киноны продюсертэй байгуулсан улсын гэрээний үндсэн дээр тухайн санхүүгийн жилд кино урлагт холбооны төсвөөс хуваарилсан хөрөнгийн хэмжээгээр хөрөнгө хуваарилах, эсвэл тухайн санхүүгийн жилийн холбооны төсвийн тухай холбооны хууль, төлөвлөгөөт үед заасан тохиолдол болон нөхцөл, тэдгээрийн дагуу Оросын Холбооны Улсын Засгийн газраас батлагдсан эрхзүйн хэм хэмжээ тогтоосон актын дагуу холбооны төсвөөс тусламж үзүүлэх замаар шийдвэрлэнэ.

Кино урлагийн салбарын асуудал эрхэлсэн холбооны гүйцэтгэх засаглалын төрийн захиргааны байгууллага Оросын Холбооны Улсын нутаг дэвсгэр дээр үндэсний кино үзүүлэх кино гаргагчид кино гаргахад /олшруулах, зар сурталчилгаа болон бусад/ зориулсан хөрөнгийг тухайн жилийн холбооны төсөвт кино урлагт зориулсан зардлын хэмжээнд хуваарилах шийдвэр гаргана. Энэ нь төсөвт өртгийн 70 хувиас хэтэрч

Мөн үндэсний кино "А" зэрэглэлийн олон улсын киноны наадамд оролцоход төсвөөс тусламж үзүүлдэг.

	Румын Улсын Киноын тухай хууль	Франц Кино үйлдвэрлэлд үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн тухай 1999 оны 2-р сарын 24-ний 99-130 тоот захирамж
Салбарын байгууллага, чиг үүрэг		
- Бодлогын	Соёл, Үндэсний Өвийн Яам ("Ministry of Culture and National Heritage").	Соёлын яам
- Хэрэгжилтийн	Киноны Үндэсний Төв ("National Centre of Cinematography"). Үндсэн чиг үүрэг: - Киноны салбарын бүртгэлийг ("Registry of Cinematography") хөтлөнө - Кино ба кинотеатрын ангилал, зэрэглэлийг тогтооно - Үндэсний киноны өвийг хадгалах, хамгаалах, сэргээн засварлах, сурталчлах, арилжааны зориулалтаар ашиглах ажлыг зохион байгуулна, үүнд	Кино урлагийн үндэсний төв. Яамны харъяа. Үндсэн чиг үүрэг: 1/ зохицуулалт хэрэгжилтийн, 2/ кино, видео, ТВ, мультмедиа салбарыг дэмжих, 3/ ТВ, киног нийтэд түгээхийг дэмжих, 4/ киноны өвийн санг хадгалах, хамгаалах.  Кино урлагийн үндэсний төвийн ерөнхий захиралын харъяалалд "Зөвшөөрлийн комисс" нэртэй санхүү, техник ба уран сайхны мэргэшсэн хүмүүсээс бүрдсэн комисс байгуулагдана. Комисс нь Кино урлагийн үндэсний төвд хандсан хөрөнгө оруулалтын болон үйлдвэрлэлийн

	<p>шаардлагатай санхүүжилтыг гаргах,</p> <ul style="list-style-type: none"> <li>- Киноны Санг ("Cinematographic Fund") бүрдүүлэх, захиран зарцуулах,</li> <li>- Нээлттэй уралдаант шалгаруулалтыг зохион байгуулна,</li> <li>- Төсөл, кино продакшн-д зээл олгоно,</li> <li>- Кино урлагийн боловсрол, соёлыг дэмжих, үндэсний киног түгээх, дэлгэрүүлэх, арт-киног дэмжих зорилгоор буцалтгүй санхүүжилт олгоно,</li> <li>- Киноны сангийн санхүүжилтын үр дүнг хянаж, гэрээний нөхцлийг зөрчсөн тохиолдолд олгосон зээл, татаасыг эргүүлэн авна,</li> <li>- Кино наадам зохион байгуулах, олон улсын кино наадамд үндэсний киног оролцуулахад санхүүжилт олгоно,</li> <li>- Кино салбарын шилдгийн үндэсний шагналыг ("the annual National Prize of Cinematography") олгоно, киноны бусад төрлийн шагналыг бий болгож болно,</li> <li>- Салбарын статистик мэдээг хөтлөнө,</li> <li>- Киноны мэргэжилтнийг бэлтгэх, ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулж, санхүүжүүлнэ, мэргэжлийн гэрчилгээ олгоно,</li> <li>- Салбарын мэргэжлийн ТББ, холбоо нийгэмлэгтэй хамтран хуулийн хэрэгжилтийг хянана, хангана,</li> <li>- Олон улсаас санхүүжилт татах, хөрөнгө босгоход дотоодын уран бүтээлчдэд мэргэжил-арга зүйн туслалцаа дэмжлэг үзүүлнэ.</li> </ul> <p>Төвийн өөрийн орлогын эх үүсвэр:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Үндэсний киноны өвийн сан дахь хөрөнгийг ашигласан, түрээсэлсэн, борлуулсны орлого,</li> <li>- Киноны ангилал, зэрэглэлийг тогтоох, Киноны салбарын бүртгэлд ("Registry of Cinematography") бүртгэх үйлчилгээний хураамж төлбөр (хураамж төлбөрийн хэмжээг Соёлын сайд тогтооно)</li> <li>- Хандив, тусламж</li> <li>- Сангийн 5%, үүнээс 3%-ийг Үндэсний киноны архивт үндэсний киноны хадгалалт, сэргээн</li> </ul>	<p>санхүүжилтын зөвшөөрлийн аливаа хүсэлттэй танилцана.</p>
--	--	---

	засварлалтад 2%-ийг Сангийн захиргааны зардалд тус тус зарцуулна	
- Хяналтын		Кино ангиллын Зөвлөл ("the Board of Film Classification")
Бусад байгууллага:		
- Архивын:	Киноны Үндэсний Төвийн харъяа Үндэсний киноны архив ("National Films Archive").	
- Бусад:	Киноны Үндэсний Төвийн харъяа Кино сэргээх лаборатори ("Laboratory for Film Restoration").	
Төрийн дэмжлэгийн хэлбэрүүд:		
Санхүүгийн:	<ul style="list-style-type: none"> <li>- Зээл: уралдаанд шалгарсан кино продакшн, төсөлд олгох хүүгүй зээл. Зээлийг 1/ уран сайхны, баримтат, анимейшн киноны продакшн, 2/ кино төслийг боловсруулах олгоно. Продакшны нийт төсвийн 50-иас илүүгүй хувийг олгоно.</li> <li>- Татаас: 1/ урлаг уран сайхны чанартай киног Румын улсын кино театрт гаргах, 2/ олон улсын кино наадамд оролцох, 3/ үндэсний киноны урлаг, боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр, 4/ арт-киног хөгжүүлэх төсөлд олгох буцалтгүй төлбөр.</li> <li>- Уралдааны үр дүнд олгох нийт санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг дебют уран сайхны, 5-аас доошгүй хувийг богино хэмжээний, 15-аас доошгүй хувийг баримтат болон анимейшн кинонд тус тус зарцуулна.</li> </ul>	<p>Санхүүгийн дэмжлэгийг:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Шууд</li> <li>- Сонгон шалгаруулж олгоно.</li> </ul> <p>Ингэхдээ урт хэмжээний, богино хэмжээний кинонд олгох санхүүжилт өөр өөр журам, нөхцөлтэй байна. Жишээ нь, урт хэмжээний киноны санхүүжилтыг дараахь хүрээнд олгоно:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тухайн бүтээлийг үйлдвэрлэх нийт зардлын 50-иас дээш хувь, хэрэв олон улсын хамтын бүтээл бол Францын талын оролцооны 50-иас дээш хувь;</li> <li>- Улсын тэтгэлгээс олгосон нийт мөнгөн дүнгийн хэмжээ нь тухайн бүтээлийг үйлдвэрлэх нийт зардлын 50-иас дээш хувь, хэрэв олон улсын хамтын бүтээл бол Францын талын оролцооны 50-иас дээш хувь тус тус хэтэрч үл болно.</li> </ul> <p>Хамтарсан бүтээл хийж буй тохиолдолд кино үйлдвэрлэлийн байгууллагуудад олгох санхүүгийн дэмжлэг нь :</p> <p>Эрх бүхий киноны байгууллагын дансанд дараах харьцаатайгаар олгогдоно :</p> <ul style="list-style-type: none"> <li>- хэрвээ 150 000 евротой тэнцүү буюу түүнээс бага бол 100 %;</li> <li>- хэрвээ 150 000 евроноос дээш бол 50 %.</li> </ul> <p>Кино үйлдвэрлэлийн 2 байгууллага хамтран томилогдсон бол тус бүрийнх нь дансанд тэнцүү харьцаатайгаар олгоно;</p> <p>Дээд тал нь 50 %-ийн харьцаатайгаар кино үйлдвэрлэлийн байгууллагуудын дансанд олгоно.</p> <p>Санхүүжилт олгох шийдвэрийг Төвийн Ерөнхий захирал гаргана.</p> <p>Мөн киноны байгууллага банк, санхүүгийн байгууллагаас зээл авахад нийт зээлийн 50</p>

		хүртэл %-ийг киноны байгууллагын өмнөөс батлан даадаг.
Санхүүгийн бус:		
Кино урлагийг дэмжих тустаа сан байдаг эсэх	Киноны Сан ("Cinematographic Fund")	"Кино урлаг болон соёлын бүтээлүүдийн үйлдвэрлэлийг санхүүжүүлэх хүрээлэн" компани ("Institut pour le financement du cinéma et des industries culturelles")-ийн дэргэдэх сан. Тус компанийн хувьцааг төр, мөн 20 гаруй хувийн банк, санхүүгийн томоохон компаниуд хамтарч эзэмшдэг. 18 сая еврогийн дүрмийн сантай, 75 сая гаруй еврогийн батлан даалтын 2 сантай. Зээл, батлан даалт, шууд санхүүжилтын үйл ажиллагаа явуулдаг.
Сангийн орлогын эх үүсвэр	<p>Төсвөөс хуваарьлах орлого:</p> <ul style="list-style-type: none"> <li>- CD, DVD-н борлуулалтын үнийн дүнгийн 2%, ХХХ ангиллын CD, DVD-ны борлуулалтын үнийн дүнгийн 10%,</li> <li>- ТВ-н эфир дэх киноны рекламны орлогын 4%,</li> <li>- Кабель ТВ-ын киноны рекламны орлогын 3%,</li> <li>- Кино театрын үзвэрийн орлогын 3%,</li> <li>- ТВ-ийн нэвтрүүлгийг кабелийн, хиймэл дагуулын, дижитал аргаар дамжуулах компанийн сарын орлогын 1%,</li> <li>- Мөрийтэй бооцоотой тоглоомын газрын жилийн орлогын 4%,</li> <li>- Кинотеатрын хувьчлалын орлогын 20%;</li> <li>- Сангийн хөрөнгөд хуримтлагдсан банкны хүү,</li> <li>- Хуульд заасан бусад.</li> </ul> <p>Дээрхи зардал нь тухайн компанийн татвар ногдох орлогоос хасах зардалд тооцно.</p>	
Сангийн хөрөнгийн зориулалт		<p>Дараахь нийтлэг үйл ажиллагааг шууд болон сонгон шалгаруулах замаар санхүүжүүлнэ:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Урт хэмжээний кино урлагийн бүтээлүүдийг бэлтгэх болон үйлдвэрлэх;</li> <li>- Богино хэмжээний кино урлагийн бүтээлүүдийг бэлтгэх болон үйлдвэрлэх;</li> <li>- Кино урлагийн бүтээлүүдийг түгээн дэлгэрүүлэх;</li> <li>- Кино урлагийн бүтээлүүдийг гадаадад сурталчлах;</li> <li>- Зарим кино урлагийн бүтээлүүдийг кино үзвэрийн танхимд гаргах;</li> <li>- Кино үзвэрийн байгууллагуудыг шинэчлэх болон байгуулах.</li> </ul> <p>Санхүүжилтыг кино урлагийн нийтлэг ашиг сонирхолд нийцсэн улсын болон хувийн</p>

		<p>хэвшлийн байгууллагуудын дараах үйл ажиллагаанд зориулна :</p> <ul style="list-style-type: none"> <li>- Кино урлагийг Францад сурталчлах;</li> <li>- Францын кино урлагийг гадаадад түгээх;</li> <li>- Францын кино урлагийн үйлдвэрлэлийг Францад болон гадаадад сурталчлах;</li> <li>- Дуу болон дүрсний мэргэжилтэн бэлтгэх, тухайлбал нарийн мэргэжлийн шаардлагад нийцсэн сургалтын тусгай хөтөлбөрт тэднийг хамруулах.</li> </ul>
Санхүүжилтын журам/шаардлага:	<ul style="list-style-type: none"> <li>- Киноны салбарын бүртгэлд бүртгүүлсэн хуулийн этгээд, хувь хүн Сангаас зарласан уралдаанд оролцох эрхтэй</li> <li>- Төрийн өмчийн компани, байгууллага оролцох эрхгүй. Харин төрийн компани, байгууллага нь төслийн хэд хэдэн продюсерын нэгээр оролцож байгаа бол уралдаанд оролцох эрхтэй.</li> <li>- Уралдааныг жилд 2 удаа зохион явуулна. Уралдааныг тусгай шүүх бүрэлдэхүүн тодорхой журам, нөхцлийн дагуу дүгнэн явуулах ба дараахь үндсэн зарчмуудыг баримтлана. Үүнд: 1/ кино бүтээх эрх чөлөө, уран сайхны илэрхийлэл 2/ үндэсний соёл, 3/ олон улсын хамтын бүтээл, 4/ залуу уран бүтээлчдийг дэмжих.</li> <li>- Кино төслийн уралдааныг урт ба богино хэмжээний кино гэсэн 2 тустаа категориийн дагуу зохион явуулна</li> <li>- Уралдааныг тустаа 2 шүүх комисс дүгнэнэ. Үүнд, 1/ бүтэн ба богино хэмжээний уран сайхны киног 5 шүүгчийн, 2/ баримтат ба анимейшн киног 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй комисс.</li> <li>- Шалгарсан төслийн эзэнтэй гэрээ байгуулна.</li> <li>- Зээлийг тус зээлээр бүтээсэн киноны бүх төрлийн орлогоос гэрээнд заасан нөхцөл журмын дагуу эргэн төлнө. Зээлийг 10 жилийн хугацаанд эргэн төлнө. Хугацаанд эргэн төлөөгүй бол Төв киноны эрхийг өөртөө шилжүүлэн авч, зээлийн үлдэгдлийг нөхөн төлүүлсний дараа эрхийг буцаан олгоно.</li> </ul>	Санхүүгийн дэмжлэгийг зөвхөн Франц Улсад бүртгэлтэй киноны байгууллагад олгоно.
Үндэсний киноны тодорхойлолт	"Үндэсний кино" гэж дараахь үзүүлэлтийн дагуу нийт боломжит 100 онооноос 65-аас доошгүй, "Румын оролцоотой кино" гэж дараахь	<p>Үйлдвэрийн байгууллагууд дараах нөхцлүүдийг хангасан байх ёстой :</p> <p>1. Ерөнхийлөгч, захирал буюу эзэн нь Францын</p>

	<p>үзүүлэлтийн дагуу нийт боломжит 100 онооноос 65-аас доошгүй оноо авсан бол:</p> <p>1/ зохиолчид:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Найруулагч 15</li> <li>- Зохиолыг бичигч 7</li> <li>- Хөгжмийн зохиолч 3</li> </ul> <p><b>Нийт: 25 оноо</b></p> <p>2/ продюсер 15</p> <p>3/ румын хэл дээр 10</p> <p>4/ жүжигчид</p> <ul style="list-style-type: none"> <li>- Гол дүр 10</li> <li>- Туслах дүр 5</li> </ul> <p><b>Нийт 40 оноо</b></p> <p>5/ бусад уран бүтээлч, оролцогч</p> <ul style="list-style-type: none"> <li>- Зургийн дарга/ерөнхий оператор 4</li> <li>- Зураач ("scenography") 1</li> <li>- Хувцас чимэглэгч 1</li> <li>- Дууны инженер 2</li> <li>- Нүүр хувиргагч 1</li> <li>- Image editor 2</li> <li>- Бусад техникч 2</li> <li>- Туслах ажилтан 2</li> </ul> <p><b>Нийт 15 оноо</b></p> <p>6/ зураг авалт, тоног төхөөрөмж, пост-продакшн:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Зураг авалт (талаас доошгүй нь Румынд бол) 4</li> <li>- Лаборатори 2</li> <li>- Тоног төхөөрөмж 4</li> <li>- Дууны пост-продакшн 5</li> <li>- Лаботари, монтаж 5</li> </ul> <p><b>Нийт: 20 оноо</b></p> <p><b>Нийт: 100 оноо</b></p>	<p>иргэн байх, эсвэл Европын Хамтын Нийгэмлэгийн гишүүн орны иргэн, хил дамнасан телевизийн тухай Европын конвенцийн гишүүн орны иргэн, Европын Зөвлөлийн кино урлагийн хамтарсан бүтээлийн тухай конвенцийн гишүүн орон эсвэл Европын Хамтын Нийгэмлэгтэй дуу, дүрсний салбарт хэлэлцээр хийсэн Европын гуравдагч орны иргэн байх,</p> <p>2. Худалдааны хуулийн L. 233-3-р зүйлийн агуулгын дагуу, 1-д заасан Европын орнуудаас бусад орны иргэн болох нэг болон олон тооны хувь хүн болон хуулийн этгээдэд захирагдахгүй байх.</p>
<p><b>Шаардлагатай Зөвшөөрөл, бүртгэл</b></p>		
<p>- Кино зураг авах</p>		
<p>- Импорт</p>		



- Дистрибьютор		Кино Урлагийн Төвөөс үйл ажиллагааны зөвшөөрөл авна
- Кино театрт гаргах		
- Кино театр нээж ажиллуулах		
<b>Киноны ангилал</b>		
- Үзэх насны	Киноны Үндэсний Төв киноны ангилал, зэрэглэлийг тогтооно	- Бүх насны - 12+ - 16+ - 18+ - Хориотой кино
- Урт/богино	Урт: 70-аас илүү мин Богино: 60-аас бага мин	- Урт: 1 цагаас илүү. Мөн 70 мм-ийн форматтай, 1 - зурганд 8-аас доошгүй нүхтэй, 8-аас дээш минут үргэлжилдэг хальсан дээрх киног урт хэмжээний кинонд тооцно. - Богино: 1 цаг буюу түүнээс бага хугацаатай.
- Бусад		
Кинотеатрт тавих шаардлага	Киноны Үндэсний Төв кинотеатрын ангилал, зэрэглэлийг тогтооно	

## ДОЛОО.ЗӨВЛӨМЖ

Аргачлалын 9-д заасны дагуу энэхүү үнэлгээний тайлангийн 5 дахь хэсгийн “Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулсан дүгнэлт”, 6 дахь хэсгийн “Олон улсын болон бусад улсын хууль эрх зүйн зохицуулалттай харьцуулсан байдал” зэргийг харьцуулан судалсаны үндсэн дээр дараах зөвлөмжийг боловсрууллаа. Үүнд:

1. Харьцуулалтын үр дүнг харгалзан Кино урлагийг дэмжих тухай хуулийн төсөл боловсруулах хувилбар нь зорилгод хүрэх оновчтой хувилбар гэж дүгнэж байна.

---oOo---

Кино урлагийг дэмжих тухай хуулийн төслийг  
 боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан  
 судлах үнэлгээний тайлангийн хавсралт 1

**ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ**

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	<b>1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх</b>			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ биш.
	<b>1.2. Оролцоог хангах</b>			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцоо боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа холбогдох байгууллагын төлөөлөлтэй санал солилцсон ба аргачлалд заасны дагуу шууд хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх, хууль төсөл боловсруулах хувилбарыг сонгосон.
1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа холбогдох байгууллагын төлөөлөлтэй санал солилцсон ба аргачлалд заасны дагуу шууд хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх, хууль төсөл боловсруулах хувилбарыг сонгосон.	
<b>1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага</b>				

	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Аргачлалд заасны дагуу шууд хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх, хууль төсөл боловсруулах хувилбарыг сонгосон. Харин хуулийн төсөл боловсруулах хувилбарын хүрээнд "хүний эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдлыг хангах" нөхцөл бүрдэнэ.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Хуулиар зохицуулахаар Үндсэн хуульд заасан нь шударга, тэгш эрх, үр өгөөжтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн бөгөөд НҮБ-аас манай улсад өгсөн зөвлөмжид нийцэж байгаа.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Хууль зөрчсөн нь тохиолдолд бусад хуулиар буюу Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль, Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр зохицуулах ба энэ хуулиар зохицуулахгүй.
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Энэ хуулиар хүний эрхийг хязгаарлах харилцааг зохицуулахгүй.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Энэ хуулиар хүний эрхийг хязгаарлах харилцааг зохицуулахгүй.
3. Эрхагуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Соёлын салбарт үйл ажиллагаа явуулж иргэд хуулийн этгээд, төрийн байгууллагаас гадна, үндэсний эрх ашгийг хамгаалах

				хүрээнд нийт иргэд энэхүү харилцаанд хамаарна.
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Үгүй
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөл боловсруулах хувилбарын хүрээнд эрх агуулагчдын эрх ашгийг хамгаалсан зохицуулалтыг тусгана.
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	Тийм	Үгүй	Хуулийн төсөл боловсруулах хувилбарын хүрээнд хязгаарласан зохицуулалт хуулийн төсөлд тусгагдахгүй.
Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөл боловсруулах хувилбарын хүрээнд зохицуулна.
4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөл боловсруулах хувилбарын хүрээнд хүйсээр ялгаварлахыг хориглох агуулга давхар тусгагдана.
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөл боловсруулах хувилбарын хүрээнд Үндсэн хуульд заасан тэгш эрх, шударга ёсны зарчимд нийцүүлнэ.

---oOo---

### ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Хуулийн хэрэгжилтэнд тавих хяналт сайжирснаар зарим нэг нөлөөллөөс сэргийлж чадна.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөл боловсруулах хувилбарын хүрээнд эдгээр эрхийг хамгаалах хүрээнд зарчмын зохицуулалт тусгагдах тул зөрөг нөлөөтэй.
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөл боловсруулах хувилбарын хүрээнд тодорхой үр дүнг дэмжих зохицуулалт тусгана.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Зөрөг нөлөө үзүүлнэ.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөл боловсруулах хувилбарын хүрээнд зөрөг нөлөө үзүүлнэ.

	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөл боловсруулах хувилбарын хүрээнд улсын төсөвт тодорхой ачаалал үүсэх боломжтой боловч Монгол Улсын үндэсний аюудгүй байдал, эрх ашгийг хангах хүрээнд ач холбогдолтой тул ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй гэж үзлээ.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөл боловсруулах хувилбарын хүрээнд зэрэг нөлөө үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөл боловсруулах хувилбарын хүрээнд Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэх арга хэмжээг авагдана.

---oOo---

Кино урлагийг дэмжих тухай хуулийн төслийг  
боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан  
судлах үнэлгээний тайлангийн хавсралт 3

**НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ**

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
		Тийм	Үгүй	
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөл боловсруулах хувилбарын хүрээнд эерэг нөлөө үзүүлнэ.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөл боловсруулах хувилбарын хүрээнд эерэг нөлөө үзүүлнэ.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөл боловсруулах хувилбарын хүрээнд эерэг нөлөө үзүүлнэ.
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Төрийн байгууллагын үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Төрийн байгууллагын үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.



	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Төрийн байгууллагын иргэдтэй харилцахад эерэг нөлөө үзүүлнэ.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.

---oOo---

Кино урлагийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлангийн хавсралт 4

### БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
		Тийм	Үгүй	
1. Агаар	1.1. Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2. Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1. Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2. Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3. Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4. Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3. Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1. Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2. Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3. Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4. Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4. Усны нөөц	4.1. Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2. Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3. Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5. Хөрсний бохирдол	5.1. Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2. Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6. Газрын ашиглалт	6.1. Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2. Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3. Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7. Нөхөн сэргээгдэх /нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1. Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2. Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

---oOo---



БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,  
СПОРТЫН ЯАМ

# **“КИНО УРЛАГИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ**

## **“КИНО УРЛАГИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ” ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ**

### **НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

“Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.42-д “Соёлын тухай хуулийг шинэчлэн баталж, киноны тухай, музейн тухай хуулийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас хариуцан боловсруулж, Улсын их хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан байна.

“Кино урлагийг дэмжих тухай” хуулийн үндсэн зорилго нь Үндэсний киног дэмжин хөгжүүлэх, дэлхийн зах зээл дээр гарган өрсөлдүүлэх замаар үндэсний түүх, өв соёл, ёс заншлаа дэлхийд сурталчлан таниулах, кино уран бүтээлчдийн оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалах, сургалт хөгжлийг дэмжих, киноны салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татаж, эдийн засаг, гааль, татварын таатай орчинг бий болгох, кино үйлдвэрлэлийг шинэ шатанд гарган хөгжүүлэх, үүнд чиглэсэн техник технологийг нэвтрүүлэх, тэдгээрийг эдийн засгийн урамшууллын хөшүүргээр дэмжих явдал юм.

Манай улсад 1990 оноос хойш кино урлагийн салбарт төрөөс киноны талаар баримтлах бодлого алдагдаж, киноны чанар, агуулга муудаж, үзэгчдийн оюуны эрэлт шаардлагад нийцээгүй, гадаадын киноны хэв маягийг дуурайсан кинонууд дэлгэцийн орон зайг эзлэх болж, хүүхэд залуучуудын хүмүүжил төлөвшил, нийгэмд сөргөөр нөлөөлж байгаа нь киноны талаар баримтлах хууль эрхзүйн зохицуулалттай болох шаардлагыг бий болгосон. Иймээс “Кино урлагийг дэмжих тухай” хуулийн төслийг боловсруулав.

“Кино урлагийг дэмжих тухай” хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын дагуу хийлээ.

### **ХОЁР. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

“Кино урлагийг дэмжих тухай” хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуурт дараах үзүүлэлтүүдийг авч үзэх нь зүйтэй гэж үзсэн болно. Үүнд:

- Зорилгод хүрэх байдал
- Ойлгомжтой байдал
- Хүлээн зөвшөөрөгдөх байдал
- Зардал
- Харилцан уялдаа

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо.

**Хүснэгт 1. Шалгуур үзүүлэлт, шалгах арга зам**

д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх.
2	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 24, 28, 29, 30, 32 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
3	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хуулийн төслийг хэрэгжүүлэх боломжтой эсэхэд шууд нөлөөлөх аж ахуйн нэгжүүд, хэрэгжүүлэх байгууллагуудын дунд хэлэлцүүлэг хийж үнэлэх.
4	Зардал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хуулийн төслийн нөлөөллөөс иргэн аж ахуйн нэгж байгууллага, төрийн байгууллагад гарах нэмэгдэл зардлыг үнэлж тооцох.
5	Харилцан уялдаа	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан эсэхийг шалгах.

**2. 1 ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ**

**2.1.1 Зорилгодоо хүрэх байдлыг хангасан эсэх:**

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд “Кино урлагийг дэмжих тухай” хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад тухайн хуулийн төслийн зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийхийг зорьлоо.

Монгол Улсын Үндсэн хуулийн 7 дугаар зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна, “Иргэний туурвисан оюуны үнэт зүйл бол зохиогчийнх нь өмч, Монгол Улсын үндэсний баялаг мөн” гэж, Соёлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 11-д “Кино үйлдвэрлэлийг хөгжүүлэх” гэж, 21 дүгээр зүйлийн 10-д “Монгол Улсын түүхэнд холбогдох онцлог үйл явдал, он дарааллийн түүхийн талаарх баримтат кино бүтээх зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж, 21 дүгээр зүйлийн 11-д “Үндэсний уламжлалт, сонгодог болон хүүхдэд зориулсан урлагийн бүтээл, улсын захиалгаар бүтээх уран сайхны болон баримтат кинонд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ” гэж тус тус заасан.

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл Баримтлал”-ын 3.1.4.1-т “Монголын түүх, хэл, соёл, шашин, зан заншлыг хамгаалах, хөгжүүлэх, судлах ажлыг төр ивээлдээ авч, ном, сурах бичиг, кино урлагийн бүтээл туурвилыг онцгойлон урамшуулж, биет болон биет бус соёлын өвийг хамгаалан хөгжүүлнэ” гэж заасан.

Улсын Их Хурлын 2012 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого”-ын 4.1.10-т “төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд түшиглэн үндэсний уламжлалт, дэлхийн сонгодог, хүүхдэд зориулсан урлагийн бүтээл, баримтат болон уран сайхны кино, ном, хэвлэлийн шилдэг бүтээл туурвих” замаар үндэсний хөгжилд соёл, урлагийн эзлэх байр суурь, оруулах хувь нэмэр, үр ашгийг дээшлүүлэх зорилтыг дэвшүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.42-д “Соёлын тухай хуулийг шинэчлэн баталж, киноны тухай, музейн тухай хуулийг боловсронгуй болгон хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ” гэж заасан.

“Кино урлагийг дэмжих тухай” хуулийн төсөлтэй холбогдуулан Соёлын тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Гаалийн тариф, Гаалийн татварын тухай хууль, Засгийн газрын Тусгай сангийн тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн төслүүдийг тус тус боловсруулсан.

“Кино урлагийг дэмжих тухай” хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийн зохицуулалтыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийсэн. Үүнд:

	<b>Хуулийн төслийн үзэл баримтлал</b>	<b>Хуулийн төслийн зохицуулалт</b>
1	<b>Зорилт 1.</b> Үндэсний киног дэмжин хөгжүүлэх, дэлхийн зах зээл дээр гарган өрсөлдүүлэх замаар үндэсний түүх, өв соёл, ёс заншлаа дэлхийд сурталчлан таниулах	“Кино урлагийг дэмжих тухай” хуулийн төслийн 5 дугаар зүйлд “олон улсын кино наадамд үндэсний киног оролцуулахад дэмжлэг үзүүлэх, үндэсний болон олон улсын кино наадам, арга хэмжээг эх орондоо зохион байгуулах” гэж заасан нь хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангаж байна.
2	<b>Зорилт 2.</b> Гадаадын иргэн, хуулийн этгээд, продакшнуудад Монгол Улсын газар нутаг дээр кино зураг авалт хийх, кино үйлдвэрлэл явуулах эрх зүйн таатай орчин нөхцлийг бүрдүүлэх.	Хуулийн төслийн 8 дугаар зүйлд “Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу дараах этгээд хамтарсан кино бүтээх гэрээ байгуулж болно” Монгол Улсын иргэн, хуулийн этгээд; гадаад улсын иргэн, хуулийн этгээд.  11 дүгээр зүйлд “энэ хуулийн 9.1-т заасан шалгуурыг хангасан кино төсөлд уг киног

		бүтээх зориулалтаар Монгол Улсын нутаг дэвсгэрт авсан бараа, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан олгох” гэж заасан нь хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангаж байна.
3	<b>Зорилт 3.</b> Киноны зах зээлийг тэлэх зорилгоор кино түгээлт, борлуулалтын сүлжээг сэргээх, хөдөөгийн хүн амд үзүүлэх соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор кино үзвэрийн нэгдсэн сүлжээг сэргээх боломжийг бүрдүүлэх;	Хуулийн төслийн 5 дугаар зүйлд “өмчийн олон хэлбэрээр кино үзвэрийн байгууллагын хүртээмжтэй бүтцийг бий болгон ажиллуулах, зохион байгуулалтын арга хэмжээ авах”, 6 дугаар зүйлд “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга киноны тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, орон нутгийн хэмжээнд кино түгээх үйл ажиллагааг дэмжиж ажиллах” гэж тусгасан нь хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангаж байна.
4	<b>Зорилт 4.</b> Залуу хойч үеийнхнийг кино урлагаар дамжуулан эх оронч үндэсний үзэл, ёс суртахууныг төлөвшүүлэхэд чиглэсэн хүүхдэд зориулсан кино урлагийн бүтээлийг улсын захиалгаар бүтээх, санхүүжүүлэх зохицуулалтыг тусгах;	Хуулийн төслийн 5 дугаар зүйлд “энэ хуулийн 11.1 дэх заалтад заасан киног бүтээх, санхүүжүүлэх тухай журам батлах”, 11 дүгээр зүйлд “соёлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 10, 11 дахь хэсэгт заасан зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх”-ээр тусгасан.
5	<b>Зорилт 5.</b> Орчин үеийн дэвшилтэт техник, технологи бүхий кино үйлдвэрлэлийн дэд бүтцийг бий болгох;	Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд “киноны талаар төрөөс баримтлах бодлого, кино үйлдвэрлэлийг хөгжүүлэх, киноны дэд бүтэц байгуулах, киноны салбарын уран бүтээлчдийн сургалт, хөгжлийг дэмжих хөтөлбөр батлах”, 11 дүгээр зүйлд “киноны дэд бүтцэд хөрөнгө оруулах” гэж тусгасан нь хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангаж байна.

### 2.1.2 Ойлгомжтой байдал

“Кино урлагийг дэмжих тухай” хуулийн төслийн боловсруулалт нь Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангаж байна гэж үзсэн.

Хуулийн төсөл нь хуулийн анхдагч төслийн хэлбэрээр бичигдсэн 5 бүлэгтэй, хуулийн төслийн бүтцийн дугаарлалт хуульд заасан шаардлагыг хангасан байна.

Түүнчлэн бие даасан санаа бүрийг тусгай зүйлд тусгаж, заалт нь нэг өгүүлбэрээр илэрхийлэгдсэн, мөн хуулийн 30 дугаар зүйлд заасан хэл зүй, найруулгын нийтлэг шаардлагад нийцсэн байна.

Хуулийг дагаж мөрдөх хугацааг тусгайлан заах шаардлагатай эсэхийг тодруулах, эсхүл тухайн хуулийг баталсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлд зааснаар албан ёсоор нийтэлснээс хойш арав хоногийн дараа хүчин төгөлдөр болохоор зохицуулсан тул хуульд заасныг давхардуулан заахгүй байх нь зүйтэй юм.

Хуулийн төслийн ойлгомжтой байдлыг холбогдох салбарын төлөөллүүдийн дунд 8 удаа хэлэлцүүлэг явуулж, сургалт, семинарт танилцуулсан. Үүнд:

- Кинотеатр, кино үзвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг уран бүтээлчид
- Телевиз, IPTV –ийн төлөөллүүд
- Кино студи, продакшны уран бүтээлчид
- Олон улсад болон дотооддоо нэрд гарсан кино уран бүтээлчид
- Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга, мэргэжилтнүүд
- Сумдын соёлын төвийн киномеханикч, техникийн ажилтнууд
- Кино урлагийн салбарын ахмад уран бүтээлчид
- Гадаад улсын киноны уран бүтээлчидтэй уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан
- БСШУСЯ-ны Соёл, урлагийн бодлогын газрын мэргэжилтнүүд

Хэлэлцүүлгээс харахад хуулийн төсөл нь хуулийг хэрэгжүүлэх төрийн байгууллага, кино студи, продакшн, аж ахуйн нэгжийн төлөөллүүдэд ойлгомжтой болсон талаар саналаа илэрхийлсэн байна.

### **2.1.3 Хүлээн зөвшөөрөгдөх байдал**

Төрөөс киноны талаар баримтлах бодлого чиг үүрэг тодорхой бус байсныг олон улсын туршлагад үндэслэн төрөөс кино урлагийг дэмжин хөгжүүлэх, үндэсний болон арт кино, түүхэн уран сайхны , баримтат, хүүхдийн киног төрөөс дэмжин авч явах, төрийн санхүүжилтээр бүтээгдсэн кинонд хяналт тавих асуудлуудыг тусгасан нь төрийн зохицуулалт хэрэгжих нөхцөлийг бий болгосон гэж үзэж байна.

Хуулийн төслийн үр дагаварт шууд хамаарах кино театр, телевиз, IPTV, кино студи продакшн, сумдын соёлын төвийн киномеханикч, техникийн ажилтнууд болон аймаг орон нутгийн Боловсрол, соёл урлагийн газрын мэргэжилтнүүдийн дунд хэлэлцүүлэг хийсэн.

Үндэсний кино контентийг дэмжих зорилгоор хуулийн төслийн 10.3-т “кино театр, киног нэмэлтээр үзүүлэгч байгууллагын дэлгэцийн оргил цагийн жилийн



хуваарилалтад үндэсний кино, арт киноны цагийн эзлэх хувь 40 хувиас доошгүй байх” гэж заасныг зарчмын хувьд хүлээн зөвшөөрч байгаагаа илэрхийлсэн саналыг кинотеатр, кино үзвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төлөөллүүдээс өгсөн.

Мөн түүнчлэн кино бүтээгч болон Үндэсний киног дэмжих зорилгоор хуулийн төслийн 10.4-т “үндэсний кино бүтээлийг өмчлөгчийн кино түгээлтээс олох орлого нь тасалбарын борлуулалт болон бусад түгээлтийн орлогын 50 хувиас доошгүй байна” гэж заасныг зарчмын хувьд хүлээн зөвшөөрч байгаагаа илэрхийлсэн саналыг кинотеатр болон бусад аж ахуйн нэгжийн төлөөллүүд өгсөн.

Хэлэлцүүлгийн үед гарсан саналыг хуулийн төсөлд тусгасан. Тухайлбал, Аймаг, орон нутагт кино үзвэрийн байгууллагын хүртээмжтэй бүтцийг төсөвт ачаалал бага үүсгэхээр зохицуулалт хийж, өнөөгийн байдлаар үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа 21 аймгийн Хөгжимт жүжгийн театрт кино дэлгэц суурилуулах замаар орон нутгийн хөрөнгөөр шийдвэрлүүлэх, олон улсын кино наадмын арга хэмжээ нь Арт кинонд зориулагдаж зохион байгуулагддаг тул үндэсний киног дэлхийд гаргахын тулд Арт киног төрөөс дэмжин авч явах нь зүйтэй гэсэн саналууд гарсан

#### **Иргэн, аж ахуйн нэгжид үзүүлэх нөлөөлөл:**

“Кино урлагийг дэмжих тухай” хууль батлагдсанаар тус хуулийн хүрээнд эрх ашиг нь хөндөгдөж байгаа иргэн, хуулийн этгээдийн хувьд /кинотеатр, ТВ, IPTV, кино студи, продакшн, кино жүжигчид гэх мэт/ сөргөөр нөлөөлөх нөхцөл үүсэхгүй бөгөөд харин эрхзүйн зохицуулалтыг бий болгосноор киноны салбарын үйл ажиллагааны чанар, хүртээмж нэмэгдэж, киноны салбарт бүтээн туурвиж, ажиллаж байгаа кино уран бүтээлчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах нөхцөл сайжирна.

#### **2.1.4 Харилцан уялдаа**

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурын дагуу үнэллээ.

- *Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх: Тийм*

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-т заасан асуултад хариулах замаар харилцан уялдааг үнэлэв. Үүнд:

<b>д/д</b>	<b>Асуулт</b>	<b>Хариулт</b>	<b>Дүн шинжилгээ</b>
1	4.10.1.хуулийн төслийн	Тийм	

	зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;		
2	4.10.2.хуулийн төслийн "Хууль тогтоомж" гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Мөн	
3	4.10.3.хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	Тийм	
5	4.10.4 Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Тийм	
6	4.10.5.хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Үгүй	
7	4.10.9.төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Боломж бий	
8	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Тийм	Хуулийн төсөлд тусгагдсан.
9	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй	
10	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй	
11	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Үгүй	
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй	Хуулийн төсөлд иргэдийн эрхийг хязгаарласан ямар нэгэн нэмэлт зохицуулалт тусгадаагүй байна.
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Тийм	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой.

14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Өрсөлдөөний тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой.
15	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Тийм	Тухайн хуулийн зохих заалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль, Төрийн албаны тухай хуультай нийцүүлэн, холбогдох хуулиар зохицуулна.

Дээрх судалгаанаас үзэхэд “Кино урлагийг дэмжих тухай” хуулийн төсөл нь бусад хууль тогтоомжтой уялдсан, асуудал давхардаагүй байна.

## 2.1.5 Үр дүнгийн үнэлгээ, зөвлөмж, олон улсын туршлага

### Олон улсын туршлага:

Бүгд Найрамдах Унгар Улсын Үндэсний хурал (Парламент) “Киноны тухай хууль” (The Film Act)-ийг 2004 онд баталснаар төрөөс кино аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх бодлогын эрх зүйн үндсийг тавьж, уг хуулиар салбарын удирдлага зохион байгуулалт, хөгжлийн бодлого, санхүүжилтийг цогцоор зохицуулах болсон.

Тус хуулинд Бүгд Найрамдах Унгар Улсын болон бусад улсын оролцоотойгоор хийгдэх кино бүтээлийн зураг авалт, түгээлт, улсын өвийн санд бүртгэх, хадгалах, Бүгд Найрамдах Унгар Улсад импортын киноны түгээлтийн зохицуулалт, эрхзүйн орчныг тодорхой болгосон.

“Киноны тухай хууль”-тай уялдуулан “Татварын багц хууль”, “Иргэний хууль”, “Зохиогчийн эрхийн тухай хууль”, “Төсвийн тухай хууль” болон “Төрийн санхүүжилтийн тухай” хуулиудад тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Бүгд Найрамдах Унгар Улсад кино аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх, тус улсыг Евро бүсийн кино урлагийн төв болгосноор Унгарын түүх, соёл, байгаль, ахуй амьдрал, үндэсний зан заншил, өв уламжлалыг дэлхий дахинд сурталчлах, санхүүжилтийн шинэ эх үүсвэрүүдийг бий болгож, гадаадын кино зураг авалт, хөрөнгө оруулалтыг татах, салбарын эдийн засагт үзүүлэх хувь нэмрийг өсгөх зорилгоор тус Унгарын нутаг дэвсгэрт зураг авалт хийж буй гадаад улсын кинонд 30 хувийн татварын хөнгөлөлт үзүүлэхээр “Аж ахуйн нэгж болон ногдол ашгийн татварын тухай хууль” “The Act LXXXI of 1996 on Corporate Tax and Dividend Tax”-д 2004 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Энэ нь Бүгд Найрамдах Унгар Улсад зураг авалт хийж буй гадаадын киноны тоог болон гадаадын хөрөнгө оруулалтыг эрс нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтөд эрс нөлөөлсөн байна. Бусад улс оронтой харьцуулахад Бүгд Найрамдах Унгар Улсад дунджаар 40-60 хувийн бага зардлаар кино бүтдэг гэсэн судалгаа гарчээ.

“Киноны тухай хууль”-иар хуульчлагдсан кино аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх, киноны урлагийн бүтээлд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, кино фестиваль, арга хэмжээнүүдийг ивээн тэтгэх, кино бүтээлийг хадгалах, мэргэжлийн сургалтаар хангах, Бүгд Найрамдах Унгар Улсын кино урлагийн салбарыг гадаадад сурталчлах зорилгоор “Унгарын үндэсний киноны сан” (Hungarian National Film Fund)-г 2011 онд 5,1 тэрбум форинт (16.4 евро, 22 сая ам.доллар)-ын төсөвтэйгээр байгуулж, сангийн 2015 оны төсвийг 18.5 сая ам. доллар байхаар баталсан. Удирдах зөвлөл нь 5 хүний бүрэлдэхүүнтэй, продакшн-компанийн статустай байдаг нь бусад улсын ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг сангаас онцлог юм.

Бүгд Найрамдах Унгар Улсын Үндэсний Хурал (Парламент)-аас “Киноны тухай хууль”-д 2012 оны 1 дүгээр сард нэмэлт, өөрчлөлт оруулан Улсын хонжворт сугалаа болох “6/45 лото”-ны ашгийн 80 хувийг тус улсын кино аж үйлдвэрийн салбарыг дэмжихэд зарцуулж байхаар хуульчилсан байна.

### **ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ, ЗӨВЛӨМЖ:**

Энэхүү үр нөлөөг тооцох үнэлгээг Соёлын тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Гаалийн тариф, Гаалийн татварын тухай хууль, Засгийн газрын Тусгай сангийн тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдэд тус тус боловсруулсан болно.

Хуулийн төслүүд дэвшүүлсэн зорилгоо хангасан эсэх, бусад хуулиудтай хэрхэн уялдсан, хэрэгжих боломж, хүлээн зөвшөөрөгдөх байдал, хуулийн төслийн найруулга, хэл зүй ойлгомжтой эсэх, зардал гэсэн шалгуур үзүүлэлтүүдээр хийсэн үнэлгээг нэгтгэн дараах дүгнэлтийг хийлээ.

### **ДҮГНЭЛТ:**

**Зорилгодоо хүрэх байдал:** Хуулийн төслийн зохицуулалт нь төслийн үзэл баримтлалд тусгагдсан зорилтуудыг бүрэн хангаж байна гэж үзэж байна. Цаашид кино урлагтай холбогдох харилцааг журамд илүү нарийвчлан тусгаж өгөх шаардлагатай.

**Ойлгомжтой байдал:** Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 24, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг агуулга, хэлбэрийн хувьд хангасан, ойлгомжтой болсон байна.

**Хүлээн зөвшөөрөгдөх байдал:** Шууд нөлөөлөл үзүүлэх этгээдүүдийн дунд хийсэн санал асуулга, хэлэлцүүлгийн дүнд зарчмын хувьд хэрэгжих боломжтой нь тогтоогдсон.

**ЗӨВЛӨМЖ:** “Кино урлагийг дэмжих тухай” хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг зохих журмын дагуу хийж гүйцэтгэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

**Нэг.** Хууль батлагдсантай холбогдуулан дагалдан гарах Засгийн газрын тогтоол, хөтөлбөр, төрийн захиргааны төв байгууллагын дүрэм, журмуудыг шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.

- Киноны талаар төрөөс баримтлах бодлого, кино үйлдвэрлэлийг хөгжүүлэх, киноны дэд бүтэц байгуулах, киноны салбарын уран бүтээлчдийн сургалт, хөгжлийг дэмжих хөтөлбөр батлах;

- Улсын захиалгаар Түүхэн болон уран сайхны кино бүтээхэд төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам батлуулах;

- Киноны мэргэжлийн холбоод, уран бүтээлчид, шинжлэх ухааны байгууллага, судлаачдын төлөөлөл бүхий киноны мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн ажиллах журмыг батлах;

- Гадаад кино, хамтарсан кинонд Монгол Улсын нутаг дэвсгэрт кино зураг авах зөвшөөрөл олгох журмыг батлах;

- Монгол Улсын Гэгээрлийн сайдын “Эрх шилжүүлэх, хураамж, үйлчилгээний хөлсний хэмжээг батлах тухай” 1999 оны 226 дугаар тушаалыг шинэчлэх;

### **Хоёр.**

Киноны салбарын дүн мэдээг нэгтгэх, статистикийн мэдээллийг боловсруулах, киноны хөгжлийг дэмжих судалгаа, шинжилгээ хийх, киноны мэдээллийн сан үүсгэх зэрэг хууль хэрэгжих явцад гарч болох хүндрэлтэй асуудал байгааг анхаарч, төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээдийн хоорондын хамтын ажиллагааг сайжруулахад Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бодлогоор дэмжлэг үзүүлэх;

### **Гурав.**

“Кино урлагийг дэмжих тухай” хуулийн хэрэгжилтийг хангахын тулд хуулийг олон нийтэд сурталчлан таниулах, хуулийн үйлчлэлд хамаарах кинотой холбогдох мэдлэг, мэдээллийг тухай бүр хүргэх, мөн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх төрийн байгууллагын ажилтан, албан хаагч нарт сургалт, семинарыг тогтмол зохион байгуулах нь зүйтэй.